ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/03/СТА-ОНӨААН

	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 261663 Цахим хаяг: sarantuyab@ audit.gov.mn
Цахим хуудас: www.govisumberaudit.mn	Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 261885 Цахим хаяг: naranbayarg@ audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 261740 Цахим хаяг: batsakihants@ audit.gov.mn
Чойр хот 2022 он	Аудитор: Утас: 260512 Цахим хаяг: Гэрээгээр гүйцэтгэсэн Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн Захирал Ш.Ичинхорлоо Утас77280808 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... 4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан..... 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 6
3. Аудитын тайлан 7
3.1 Ерөнхий зүйл 7
3.2 Дотоод хяналт 7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 7
3.4 Материаллаг байдал 8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга 8
4.1 Байгууллагын үйл ажилагаа 8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин..... 8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого 9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 10
5.1 Шилэн дансны мэдээлэл..... 10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 11
8. Аудитын илрүүлэлт..... 11
8.1 Залруулсан алдаа..... 11
8.2 Төлбөрийн акт 12
8.3 Албан шаардлага..... 12
8.4 Зөвлөмж..... 12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

“ТАЛЫН ИЛЧ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ

А. БАТЖАРГАЛ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон ба Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн баталсантай холбоотойгоор аймгийн эрчим хүч, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд айл өрх, ААНБ-уудын дулаан, цэвэр бохир усны хөнгөлөлт чөлөөлөлтөд нийт 60.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 51.1 сая төгрөг олгож, 9.0 сая төгрөгийг олгоогүйгээс авлага үүссэн байна. Нийт санхүүжилтийн 60.1 сая төгрөгөөс дулаан 33.9 сая төгрөг, цэвэр бохир ус 26.2 сая төгрөг төлбөр байна.

/АОУС 701-ийн шаардлагын дагуу аудитын гол асуудал бүрийн тайлбар/

Бусад мэдээлэл

2021 оны жилийн эцэст Баянтал сумын 16 байгууллага, 130 өрх айлыг цэвэр ус болон дулаанаар ханган ажилласан. Тайлант онд 1.86, 2.33, 1.6 мегаваттын хүчин чадалтай 2 зуухын яндантай нь суурилуулж, уурын зуухны гадна, дотно талыг камержуулж ажилласан байна.

Тайлант онд Мэргэжлийн Хяналтын газартай хамтран ажиллах гэрээний ундны усны шинжилгээг улирал болгон шинжлүүлэн аюулгүй байдлын ханган ажиллаж, ундны эх

үүсвэрийг хамгаалан самбар байршуулсан байна. Бохир усны 36 худгийг 4 удаа цэвэрлэн,агаар бохирдох, эвгүй үнэр гаргахаас хамгаалан ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Хөрөнгө	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1091175.41	1977875.08
1.1.02	Дансны авлага	30215579.12	31371628.70
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	2524050.13	2953684.80
1.1.04	Бусад авлага	109755.00	195133.29
1.1.06	Бараа материал	31844965.04	48451484.07
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	78000.04	0.00
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**65863524.74**	**84949805.94**
1.2.01	Үндсэн хөрөнгө	1635516892.02	1254712047.59
1.2.09		50244000.00	50244000.00
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**1685760892.02**	**1304956047.59**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**1751624416.76**	**1389905853.53**
2.1.1.01	Дансны өглөг	23387636.36	2273750.00
2.1.1.03	Татварын өр	1196876.08	3829032.47
2.1.1.04	НДШ-ийн өглөг	16850000.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	134406.32	178605.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	**41568918.76**	**6281387.47**
2.1.2.05		653605452.76	300031575.05
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	653605452.76	300031575.05
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**695174371.52**	**306312962.52**
2.3.01	Өмч;-төрийн	1572400240.20	1572400240.20
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	86304329.64	86304329.64
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-602254524.60	-575111678.83
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	27070669.41
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-602254524.60	-602182348.24
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**1056450045.24**	**1083592891.01**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**1751624416.76**	**1389905853.53**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	**Үзүүлэлт**	**Өмнөх оны дүн**	**Тайлант жилийн дүн**
01	Борлуулалтын орлого (цэвэр)	302604508.67	363899662.70
02	Борлуулалтын өртөг	262257737.39	229868970.51
03	Нийт ашиг (ашиг)	40346771.28	134030692.19
05	Хүүний орлого	104711.48	0.00
08	Бусад орлого	51391040.47	17242449.72
08.1	Орлогын дүн	51495751.95	17242449.72
09	Борлуулалт, маркетингийн зардал	10981868.74	10706309.53
10	Ерөнхий удирдлагын зардал	123705063.55	110121833.73
12.1	Зардлын дүн	134686932.29	120828143.26
17	Бусад ашиг(алдагдал)	0.00	-366477.08
17.1	Олз, гарзын дүн	0.00	-366477.08
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-42844409.06	30078521.57
19	Орлогын татварын зардал	10471.15	3007852.16
20	Татварын дараах ашиг	-42854880.21	27070669.41
22	Тайлант үеийн цэвэр ашиг	-42854880.21	27070669.41

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл**	**1572400240.20**	**86304329.64**	**-602254524.60**	**1056450045.24**
2	НББ-ын бодлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	72176.36	72176.36
3	Залруулсан үлдэгдэл	1572400240.20	86304329.64	-602182348.24	1056522221.60
4	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	27070669.41	27070669.41
5	**2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл**	**1572400240.20**	**86304329.64**	**-575111678.83**	**1083592891.01**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**305157713.57**	**391251504.38**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	302822464.32	381023999.22
1.1.6	Бусад мөнгөн орлого	2335249.25	10227505.16
1.2	**Мөнгөн зарлагын дүн (+)**	**310798784.21**	**385395304.71**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	113598078.03	113671794.24
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18226545.94	53045915.64
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	36854085.00	49410799.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23391877.15	27620081.21
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	54978094.97	91838810.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	28362681.78	37220087.29
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1131855.00	1089525.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	34255566.34	11498292.33
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**5641070.64**	**5856199.67**
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	870000.00	4899500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	870000.00	4899500.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	70000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	870000.00	4969500.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**6511070.64**	**886699.67**
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7602246.05	1091175.41
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1091175.41	1977875.08

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлого нэр төрлөөр	**Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт**					
	Халаалт	273,929,700	248,262,000	284,766,800	(36,504,800)	115
	Цэвэр ус	14,996,800	11,619,300	41,249,300	(29,630,000)	355
	Бохир ус	12,538,300	10,689,000	19,331,600	(8,642,600)	181
	Засвар	1,139,700		18,551,900	(18,551,900)	
	Бусад орлого	5,313,600	2,000,000	4,510,800	(2,510,800)	226
	Үнэ төлбөргүй орлого	46,182,200	30,182,200	12,731,700	17,450,500	42
					-	
Нийт орлогын дүн		**354,100,300**	**302,752,500**	**381,142,100**	**(78,389,600)**	**126**
Үүнээс: Цэвэр Борлуулалт		302,604,500	270,570,300	363,899,600	(93,329,300)	134
Нийт зардал		**396,944,700**	**349,251,100**	**351,063,600**	**(1,812,500)**	**101**
Зардлын төрлөөр	ББӨ	262,257,700		229,869,000	(229,869,000)	
	Ерөнхий ба удирдлагын зардал	123,705,100		110,488,300	(110,488,300)	
	Борлуулалтын зардал	10,981,900		10,706,300	(10,706,300)	
Цэвэр шиг алдагдал		(42,854,900)	(46,498,600)	27,070,700	(73,569,300)	(58)
Хөрөнгө оруулалт, их засвар			-	-	-	
Нийт ашиг алдагдал		(42,844,400)	(46,498,600)	30,078,500	(76,577,100)	(65)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төлөвлөлттэй, өглөг ,бараа материал, анхан шатны баримт бүрдүүлэлт, засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт, шилэн данс холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, гүйцэтгэж, анх шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг төрийн аудитын менежер Г.Наранбаяр, дарга. Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар гүйцэтгэв.

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын үйл ажиллагааны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бичиг хэрэг, хүний нөөц, санхүү, уурын зуухны ашиглалт гэсэн 4 чиглэлээр дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө батлуулан ажилласан байна.

2021 оны дотоод хяналт шалгалтын ажилтны төлөвлөгөө болон дотоод хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 сарын 31-ны байдлаарх 120.8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Талын илч” ОНӨААТҮГ нь “Хэрэглэгчдийг дулаан, хэрэглээний цэвэр усаар тогтмол хангах бохир усыг татан зайлуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Дулааны эрчим хүчээр хэрэглэгчдийг хангах, цэвэр ус олборлох, хэрэглэгчдэд шаардлага хангасан цэвэр ус түгээх, бохир усанд анхан шатны цэвэрлэгээ хийж зайлуулах, хэрэглэгчдийн захиалгаар засвар үйлчилгээ хийх” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Талын илч” ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын захирамжаар 1999 онд байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

“Талын илч” ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бөгөөд аймгийн Засаг даргатай тайлант оны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд аймгийн ИТХ-ын тогтоолоор арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр

ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2021 онд бүтэц, орон тоо, цалин санд өөрчлөлт ороогүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг үнэ тарифт дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон,
- ✓ Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн батлсантай холбоотойгоор аймгийн эрчим хүч, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Талын илч” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс батлсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.1	2.0	0.9
Авлага	32.8	34.5	1.7
Бараа материал	31.8	48.4	16.6
Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	1,635.5	1,254.1	(381.4)
Биет бус хөрөнгө	0.00	0.00	0.00
Нийт хөрөнгийн дүн	**1,751.6**	**1,389.9**	**(361.7)**
Өр төлбөрийн дүн	695.2	306.3	(388.9)
Богино хугацаат өглөг	41.6	6.3	(35.3)
Урт хугацаат өглөг	653.6	300.0	(353.6)
Эздийн өмч	1,572.4	1,572.4	0.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**1,751.6**	**1,389.9**	**(361.7)**

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд 0.9 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэлд дараах авлагууд бүртгэлтэй байна.

Үүнд: ХХОАТ-аас авах 2.9 сая, бусад татварын авлаг 0.02 сая, Засгийн газраас 31.4 сая төгрөгийн авлага тус тус байна.

Тайлант онд Засгийн газраас айл өрх, ААНБ-ын дулаан, цэвэр, бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг олгосон ажлын хүрээнд үүссэн Засгийн газраас авах авлага 31.4 сая төгрөг буюу 90 хувийг эзэлж байгаа нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэл хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.4 сая төгрөг болж 16.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд бэлтгэсэн бараа материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 384.1 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн дугаар 40 тогтоолын дагуу “Илчлэг шивээ”ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсэн нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 6,3 сая төгрөг байна. Богино хугацаат өр төлбөрт нүүрсэнд 2.3 сая, татварт 3.8 сая, татварт, ажилчидтай холбоотой өглөг 0.1 сая төгрөг тус тус өглөгтэй байна.

Санхүүгийн тайланд өртөг, зардлын талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлага, борлуулалт маркетингийн зардал гэж ангилан бүртгэж, тайлагнасан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Талын илч” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн Засаг даргатай 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дугаар 19/2021 хамтран ажиллах гэрээ байгуулан “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 302.7 сая төгрөг, нийт зардлыг 349.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 381.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 351.1 сая төгрөгийн зардал гарган, 30.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 381.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 78.3 сая төгрөг буюу 25.8 хувиар давахад тайлант онд үйл ажиллагаа жигд явагдсан болон татаас санхүүжилт болон зарим үйл ажиллагааны орлого орсон зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 351.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.9 сая төгрөг буюу 0.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ажил үйлчилгээнээс шалтгаалсан байна.

Тайлант онд алдагдал 54.8 сая төгрөг болж, төлөвлөсөн алдагдал буурсан байна. 54.8 сая төгрөгийн алдагдал нь борлуулалт маркетингийн болон удирдлага менежментийн өссөнтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Талын илч” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 857.9 сая төгрөгийн тухай бүр 7, хагас жил 5, нийт 12 мэдээлэл хоцроож, тухай бүр 8, сар бүр 3, улирал бүр 1, нийт 12 мэдээллийг мэдээлээгүй байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд

Тайлант онд тэмцээн уралдаанд 0.09 сая, бүжгийн сургалтад 0.05 сая, урамшуулалд мөнгөн аяга 0.4 сая төгрөг, нийт 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.4 цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх; 1.5-д “.... сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6-д “... спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалтын мэдээлэл нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтын заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 5 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2.	2	2.	0.0	0.0	100
Нийт дүн	**2**	**2.**	**2**	**2.**	**0.0**	**0.0**	100

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,118.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 251.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 867.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 260.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 3.0 сая төгрөгийн түвшинээс 257.5 сая төгрөгөөр их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

8.3 Албан шаардлага

8.3.1 Аймгийн засаг даргын баталсан зарим төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь ".... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх", Говьсүмбэр аймгийн засаг даргатай байгуулсан 2021 оны гэрээний 3.28-д: "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн.....” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөнд зохицуулалт хийлгэж ажиллаагүй тул албан шаардлага өгөх

8.3.2 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 204.2 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь заалт, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх “... анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8.3.3 Тайлант онд БНХАУ-ын Эрээн хотоос байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авсан боловч анхан шатны баримт материалыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” гэж заасны дагуу бараа, ажил үйлчилгээний худалдан авалт бүрд дахин давтагдашгүй төлбөрийн баримтыг заавал хавсаргах' гэсэнтэй нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт*:

Тайлант онд 6.3 сая төгрөгийн өглөг үүссэн. Энэ Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “авлага, өр төлбөрийн төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, "Говьсүмбэр аймгийн засаг даргатай байгуулсан 2021 оны гэрээний 3.28-д: "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

зориулалтын дагуу зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр, авлага үүсгэхгүй ажиллах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй.

1.2. *Өгсөн зөвлөмж:* авлага, өглөг үүсгэхгүй байх, тооцоо нийлж, баталгаажуулж байх.

2. Төлөвлөлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс зарим зардал хүрэлцэхгүй өр төлбөр нэмэгдэх эрсдэл бий болсон

2.2. *Өгсөн зөвлөмж*:

Төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, зарцуулж байх

3. Төлөвлөгөөт зардлын зарцуулалттай холбоотой асуудал

3.1. *Илрүүлэлт:*

Аймгийн засаг даргын баталсан төлөвлөгөөг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д"*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь "*.... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Ангилал”* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Баталсан төлөвлөгөөт зардлын хүрээнд зарцуулах, шаардлагатай тохиолдолд зардлыг тодотголд тусгах асуудлыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх .

4. Бараа материалтай холбоотой асуудал

4.1. *Илрүүлэлт:*

Бараа материалын дансдад үндсэн хөрөнгийн шинж чанартай 2.3 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцээгүй, “Ангилал" батламж мэдэгдэл “ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Ангилал”* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн орлогыг зөв дансанд ангилж бүртгэх

5. Анхан шатны баримттай холбоотой асуудал

5.1. *Илрүүлэлт:*

Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”

5.2. *Өгсөн зөвлөмж:*

Анхан шатны баримтыг цаг тухайд нь үнэн зөв бодитой бүрдүүлэх

6. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

6.1. *Илрүүлэлт:*

Тайлант онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 857.9 сая төгрөгийн тухай бүр 7, хагас жил 5, нийт 12 мэдээлэл хоцроож, тухай бүр 8, сар бүр 3, улирал бүр 1, нийт 12 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 заалтууд, эрх, үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

6.2. *Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн дагуу холбогдох мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах

7. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

7.1. *Илрүүлэлт:*

Тайлант онд тэмцээн уралдаанд 0.09 сая, бүжгийн сургалтад 0.05 сая, урамшуулалд мөнгөн аяга 0.4 сая төгрөг, нийт 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.4 цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх; 1.5-д “.... сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6-д “... спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн ба эрх, үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

7.2. *Өгсөн зөвлөмж:*

Засгийн газар болон дээд шатны эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжийн хүрээнд хориглосон аливаа үйл ажиллагааг явуулахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
	УС-ДУ ОНӨААТҮГ	ГСА-2022/02/СТА-ОНӨААН	Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлт хангалтгүй	Анхан шатны баримтыг цаг тухайд нь үнэн зөв бодитой бүрдүүлэх	1										1	
			Тайлант онд 6,281.4 мянган төгрөгийн өглөг үүссэн	Авлага, өглөг үүсгэхгүй байх, тооцоо нийлж, баталгаажуулж	1	6.3									1	6.3
			Аймгийн засаг даргын баталсан төлөвлөгөөг зориулалтын дагуу зарцуулаагүй	Төлөвлөсөн ажил хэрэгжихгүй байх, баталсан төлөвлөгөөт зардал хэтрэх	1	0.1									1	0.1
			Засаг даргын баталсан зардлын төлөвлөгөөг дутуу илэрхийлсэн,	Баталсан төлөвлөгөөт зардлын хүрээнд зарцуулах, шаардлагатай тохиолдолд зардлыг тодотголд тусгах асуудлыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх	1	21.6					1	21.6				
			Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 19 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй	...анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна	1	204.2					1	204.2				

			Тайлант онд БНХАУ-ын Эрээн хотоос байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авсан боловч баримт материалыг бүрдүүлээгүй	.....импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх”	1	26.0					1	26.0	1	26.0		
			Төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс зарим зардал хүрэлцэхгүй өр төлбөр нэмэгдэх эрсдэл бий болсон	....."үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"	1								1		1	
			Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэлтэй	Үндсэн хөрөнгийг орлогыг зөв дансанд ангилж бүртгэх	1	2.3									1	2.3
ДҮН					8	260.5					3	251.8			5	8,7
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
			Shilendans.gov.mn цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 12 мэдээлэл хоцроож, 12 мэдээлэл байршуулаагүй	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д: "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх	1	857.9									1	857.9
			Тайлант онд тэмцээн уралдаанд 95.0 мянга, бүжгийн сургалтад 55.0 мянга, урамшуулалд мөнгөн аяга 390.0 мянган төгрөгийг зарцуулсан	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах	1	0.5									1	0.5
	ДҮН				2	858.4									2	858.4
НИЙТ ДҮН					10	1,118.9					3	251,8			7	867,1